



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан дөрвөн аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэг иргэний дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

5. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газар, жуулчны бааз, гэр баазад тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ


тушаалын тавдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан СББББ ЗБ Нөхөрлөл-ийн “Оюу” дэн буудлын 13/44, Оасисмон ХХК-ийн “Оасис” дэн буудлын 13/86, Ти энд Жи ХХК-ийн “Нью Вест” зочид буудлын 13/83, Тэрэлж сүйх ХХК-ийн “Тэрэлж” зочид буудлын 13/59 тоот, Зүүнбаян Рефайнери ХХК -ийн “Пийс Бридж” зочид буудлын 13/31 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

7. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

8. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 13 өдрийн
А/88 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН
ЖАГСААЛТ

2016.09.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Ти энд Жи ХХК	Нью Вест	Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 91
2	Зүүнбаян Рефайнери ХХК	Пийс Бридж	Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Дунд гол гудамж 47
3	Тэрэлж Сүйх ХХК	Тэрэлж	Налайх дүүрэг, 6-р хороо, Жо Вангийн адагт

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 13 өдрийн
А/88 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН
ЖАГСААЛТ

2016.09.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	ДБМБ ХХК	Титэм	Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Драгон төвийн 7 давхар
2	Уран Дриллинг ХХК	Уран мотел	Баянгол дүүрэг, 5-р хороо, 49/1
3	Амури Оргил ХХК	Гранд Хилл	Баянгол дүүрэг, 18-р хороо, Дамдинбазарын гудамж 52
4	Комо Юнайтед Инк ХХК	Гүүд дэй	Баянгол дүүрэг, 8-р хороо, Жамсранжавын гудамж 14

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 13 өдрийн
А/88 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН
ЖАГСААЛТ

2016.09.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	СББББ ЗБ Нөхөрлөл	Оюу	Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Дандарын гудамж 10
2	Оасис мон ХХК	Оасис	Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Чулуутын 1/10
3	Иргэн Н.Болд	Хандгайт	Сүхбаатар дүүрэг, 14-р хороо, 33/338 а

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 13 өдрийн
А/88 дугаар тушаалын дөрөвдүгээр
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ИРГЭНИЙ
ЖАГСААЛТ


2016.09.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Я.Цэнджав	Од	Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, 8 байр 1/4

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 13 өдрийн
А/88 дугаар тушаалын тавдугаар
хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭНИЙ
ЖАГСААЛТ

2016.09.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн М.Ганчимэг	Мишээл	Чингэлтэй дүүрэг, 19-р хороо, 23-р хэсгийн 2358 а